

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/158/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Амармэнд Утас: 70453721, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1Залруулсан алдаа	15
5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ӨНДӨРХАНГАЙ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ О.УРАНЧИМЭГ
ТАНАА

2022.02.25 № УВА-2022/158/НА-СТА-ТМЗ
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өндөрхангай сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200523

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,215,600.00</u>	<u>10,315,600.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,215,600.00	10,315,600.00
354	Хангамжийн материал	10,215,600.00	10,315,600.00
35410	Бичиг хэргийн материал	200,500.00	200,500.00
35420	Аж ахуйн материал	10,015,100.00	10,115,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>823,427,677.02</u>	<u>804,767,769.70</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	823,427,677.02	804,767,769.70
392	Биет хөрөнгө	820,571,677.02	801,911,769.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	789,869,094.99	789,869,094.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-43,537,280.88	-65,340,577.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,586,517.50	35,275,517.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,202,897.23	-27,427,041.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,963,967.36	39,154,967.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,865,692.72	-18,378,159.48
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	40,700,178.00	40,700,178.00
39217	Ном	8,057,790.00	8,057,790.00
393	Биет бус хөрөнгө	2,856,000.00	2,856,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,856,000.00	2,856,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>833,643,277.02</u>	<u>815,083,369.70</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>70,330.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	70,330.00	00.00
413	Өглөг	70,330.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	70,330.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>833,572,947.02</u>	<u>815,083,369.70</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	833,572,947.02	815,083,369.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	754,445,007.76	754,445,007.76
51101	Өмч: - төрийн	754,445,007.76	754,445,007.76
512	Хуримтлагдсан үр дүн	-124,741,217.42	-143,230,794.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-124,741,217.42	-124,741,217.42
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-18,489,577.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	203,869,156.68	203,869,156.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>833,643,277.02</u>	<u>815,083,369.70</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	119,302,464.00	109,807,700.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,903,864.00	9,880,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,903,864.00	9,880,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,903,864.00	9,880,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,903,864.00	9,880,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	96,398,600.00	99,927,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,398,600.00	99,927,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,398,600.00	99,927,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	125,126,543.92	128,297,277.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,126,543.92	128,297,277.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	124,308,852.92	126,144,656.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,081,356.00	54,625,932.67
210101	Үндсэн цалин	50,041,356.00	49,586,296.97
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,039,635.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,959,230.00	7,061,551.14
210201	Тэтгэврийн даатгал	4,754,830.00	5,069,464.52
210202	Тэтгэмжийн даатгал	551,100.00	513,982.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	440,900.00	412,264.99
210204	Ажилгүйдлийн даатгал	110,200.00	107,935.42
210205	Эрүүл мэндийн даатгал	1,102,200.00	957,904.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,891,983.00	32,091,065.20
210301	Гэрэл, цахилгаан	252,946.00	207,714.80
210302	Түлш, халаалт	29,639,037.00	31,883,350.40
2104	Хангамж, бараа материалын зардал	2,823,870.00	1,845,900.00
210401	Бичиг хэрэг	403,900.00	202,500.00
210402	Тээвэр, шатахуун	601,270.00	506,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,518,700.00	886,500.00
2105	Нормативт зардал	910,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	910,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,203,900.00	166,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	83,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	83,000.00
210604	Урсгал засвар	1,203,900.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	98,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	98,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	1,716,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,000.00	1,500,000.00

Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,916,513.92	28,539,907.32
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,916,513.92	28,539,907.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	817,691.00	2,152,620.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	517,691.00	1,952,620.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	517,691.00	1,952,620.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,824,079.92	-18,489,577.32
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,824,079.92	-18,489,577.32

2.4. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	96,398,600.00	99,927,700.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	96,398,600.00	99,927,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,398,600.00	99,927,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,398,600.00	99,927,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	96,398,600.00	99,927,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,398,600.00	99,927,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,580,909.00	97,775,079.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,081,356.00	54,625,932.67
210101	Үндсэн цалин	50,041,356.00	49,586,296.97
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,039,635.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,888,900.00	7,131,881.14
210201	Тэтгэврийн даатгал	4,684,500.00	5,069,464.61
210202	Тэтгэмжийн даатгал	551,100.00	513,982.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	440,900.00	412,264.57
210204	Ажилгүйдлийн даатгал	110,200.00	107,935.81
210205	Эрүүл мэндийн даатгал	1,102,200.00	1,028,234.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,891,983.00	32,091,065.20
210301	Гэрэл, цахилгаан	252,946.00	207,714.80
210302	Түлш, халаалт	29,639,037.00	31,883,350.40
2104	Хангамж, бараа материалын зардал	1,380,270.00	1,094,300.00
210401	Бичиг хэрэг	245,000.00	202,500.00
210402	Тээвэр, шатахуун	601,270.00	506,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	59,000.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	175,000.00	134,900.00
2105	Нормативт зардал	500,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,316,400.00	917,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	230,000.00	83,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	83,000.00
210604	Урсгал засвар	986,400.00	751,600.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	98,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	98,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	1,716,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,000.00	1,500,000.00

Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	817,691.00	2,152,620.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	517,691.00	1,952,620.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	517,691.00	1,952,620.99
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	754,445,007.76	203,869,156.68	-188,917,137.50	839,397,026.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	754,445,007.76	203,869,156.68	-188,917,137.50	839,397,026.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	-5,824,079.92
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	754,445,007.76	203,869,156.68	-124,741,217.42	833,572,947.02
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	754,445,007.76	203,869,156.68	-124,741,217.42	833,572,947.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	754,445,007.76	203,869,156.68	-124,741,217.42	833,572,947.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,489,577.32	-18,489,577.32
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	754,445,007.76	203,869,156.68	-143,230,794.74	815,083,369.70

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99,927,700.00	97,975,079.01	1,952,620.99	98,0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,927,700.00	97,975,079.01	1,952,620.99	98,0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,927,700.00	97,775,079.01	1,902,620.99	98,1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,626,500.00	54,625,932.67	567.33	100%
210101	Үндсэн цалин	49,586,500.00	49,586,296.97	203.03	100%
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.0	5,039,635.7	364.30	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,374,600.00	7,131,881.14	242,718.86	96.7%
210201	Тэтгэврийн даатгал	5,189,500.00	5,069,464.61	120,035.39	97.7%
210202	Тэтгэмжийн даатгал	546,300.00	513,982.05	32,317.95	94.1%
210203	ҮОМШӨ-ний даатгал	437,000.00	412,264.57	24,735.43	94.3%
210204	Ажилгүйдлийн даатгал	109,300.00	107,935.81	1,364.19	98.8%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,092,500.00	1,028,234.10	64,265.90	94.1%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,551,400.00	32,091,065.20	1,460,334.80	95.6%
210301	Гэрэл, цахилгаан	425,800.00	207,714.80	218,085.20	48.8%
210302	Түлш, халаалт	33,125,600.00	31,883,350.40	1,242,249.60	96.2%
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	0.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	1,107,000.00	1,094,300.00	12,700.00	98.9%
210401	Бичиг хэрэг	204,100.00	202,500.00	1600.00	99.2%
210402	Тээвэр, шатахуун	506,900.00	506,900.00		100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,200.00	200,000.00	200.0	99.9%
210404	Ном хэвлэл	50,000.00	50,000.00		100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	134,900.00	10,900.00	92.5%
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00		100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00		100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	918,700.00	917,900.0	800.00	99.9%
210601	Багаж, техник, хэрэгсэл	83,700.00	83,300.00		99.5%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,300.00	83,000.00	300.00	99.6%
210604	Урсгал засвар	751,700.00	751,600.00	100.00	100%
2107	Томилолт, зочны зардал	133,500.00	98,000.00	35,500.00	73.4%
210702	Дотоод албан томилолт	133,500.00	98,000.00	35,500.00	73.4%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,866,000.00	1,716,000.00	150,000.00	92.0%

Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,650,000.00	1,500,000.00	150,000.00	90.9%
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00		100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,000.00	200,000.00	50,000.00	80.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	200,000.00	50,000.00	80.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	200,000.00	50,000.00	80.0%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	99,927,700.00	99,927,700.00	0.00	99.5%
31	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	99,927,700.00	99,927,700.00	0.00	100.0%
310002	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,927,700.00	99,927,700.00	0.00	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	06.00	06.00	0.00	100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.00	
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	0.00	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	06.00	06.00	0.00	100.0%
650008	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч / ТҮСУ/	04.00	04.00	0.00	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	01.00	01.00	0.00	100.0%
650010	Гэрээт ажилтан	01.00	01.00	0.00	100.0%

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өндөрхангай сумын Соёлын төв нь төрөөс соёлын талаар баримтлах бодлого, ардын урлаг, үндэсний хөтөлбөрүүд, түүх соёлын дурсгалын зүйл, өвийг хадгалж хамгаалах, төр олон нийт ард иргэд, залуус өсвөр үеийнхний соёл хүмүүжил, оюуны болон чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяас билэг, ур чадварыг нээн илрүүлэх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн талаар хяналт мониторинг хийсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1.00.0 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 116.645.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,166.4 мянган төгрөгийн 80 хувиар буюу 933.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тэдруулга

Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,489.6 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
5	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	10,215.6	10,315.6	100.0
Үндсэн хөрөнгө	823,427.6	804,767.7	-18,875.5
Нийт хөрөнгө	833,643.2	815,083.3	-18,559.9
Өр төлбөр	70.3	0.0	-70.3
Засгийн газрын орлого /Эздийн өмч/	833,572.9	815,083.3	-18,489.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	833,643.2	815,083.3	-18,489.6

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,315.6 мянган төгрөг болж 100.0 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 804,767.7 мянган төгрөг болж 18,875.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 28,539.9 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс бэлтгэсэн 9,880.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж хүлээн авсантай холбоотой байна.

Засгийн газрын өрөлцөө дансны үлдэгдэл 815,083.3 мянган төгрөг болж 18,489.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 9,494.9 мянган төгрөгөөр буюу 8 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 3,170.7 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өндөрхангай сумын Соёлын төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 99,701.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 99,701.7 мянган төгрөгөөр тосгон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 126.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 99,927.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 99,927.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 99,927.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 99,927.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 97,975.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,952.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 97,975.0 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Өндөрхангай сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2020 оны санхүүгийн тайлангаар зөвлөмж өгсөн тул А/108 дугаар тушаалаар өгсөн ерөнхий чиглэлийн хавсралт 1 маягтаар нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 146, хугацаа хоцорсон 3, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл хугацаа хоцорч байршуулсан зөрчилд зөвлөмж өгснийг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 339.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Аудитаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилолт, аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг шууд зардалд бүртгэсэн 339.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залрууллаа.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/									
				Үүнээс				Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
1	Өндөрхангай сумын Соёлын төв	1	339.0	1	339.0								
ДҮН		1	339.0	1	339.0								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Т.АМАРМЭНД/

2022 оны 02 сарын 25-ны өдөр